



ГАРЧИГ

2–3	Бодлогын нийтлэл
4–6	Зохицуулалтын мэдээ
7–8	Байр суурь
9–10	Тайлбар ба зөвлөмж
11	Тогтвортой санхүүжилт
12–13	Финтек ба регтек
14–19	Судлаачийн индэр
20–21	Даатгалын зуучлагч, төөлөлөгч гэж хэн бэ?
22–23	Олон улсын зах зээлийн мэдээ
24	Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ



Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөнтэй ярилцлаа.

Банкны реформ амжилттай хэрэгжиж дууслаа. Энэ талаар товчхон дурдвал?

Улсын Их хурлаас банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2021 онд баталсан нь банкны салбарын реформыг эхлүүлэх үндэс болсон бөгөөд үүнтэй холбоотойгоор холбогдох журмуудыг Монголбанкт хамтран боловсруулж, банкнуудын хувьцаат компани болох төлөвлөгөөг хянахаас эхлүүлээд үнэт цаас гаргах, хувьцаат компани болохтой холбоотой сургалтуудыг зохион байгуулж, тэдгээрийн нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг бүртгэх зэрэг холбогдох ажлуудыг Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс хэрэгжүүлж ажиллалаа.

Үүний хүрээнд 2023 оны 6 дугаар сарын байдлаар банкны системд нөлөө бүхий 5 банк нийтэд санал болгон гаргаж буй хувьцаагаа бүртгүүлж, тухайн банкнуудын анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдаж дууссан. Тухайлбал 2022 онд Төрийн банк, Голомт банк, 2023 онд ХААН банк, Худалдаа хөгжлийн банк, Хас банк анх удаа хувьцаагаа олон нийтэд санал

болгон гаргасан /IPO/ нь банкны реформ амжилттай хэрэгжиж буйн илрэл болж байна.

Банкны реформ нь арилжааны банкнуудад зохистой засаглалыг бий болгох, олон нийтийн хяналттай, нээлттэй, ил тод банкны салбарыг бүрдүүлэхэд томоохон түлхэц болж буй төдийгүй зөвхөн банкны салбар бус, нийт санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, нэн ялангуяа хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой шийдвэр болсон гэдгийг энд дурдах нь зүйтэй болов уу. Үүний хүрээнд иргэд, олон нийтийн хөрөнгийн зах зээлд оролцох идэвх, сонирхол нэмэгдэж, хөрөнгийн зах зээлийн цар хүрээ өргөжин тэлж тус зах зээлийн үнэлгээ 11 их наядыг даваад байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.3 дахин өссөн буюу 6.3 их наядаар өссөн дүн бөгөөд үүний 5 гаруй их наяд төгрөг нь банкны системд нөлөө бүхий банкнууд IPO хийснээр өссөн дүн юм.

Үргэлжлэл 7-р нүүрт



ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

УЛСЫН САЛБАРЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Бараа, ажил, үйлчилгээг цаг хугацаанд нь, засгийн газар болон иргэдэд хамгийн үр ашигтайгаар олж авах үйл ажиллагаа. Худалдан авах ажиллагаа үр дүнг үнэлэх шалгуур бол хэмнэлт бөгөөд энэ нь чанартай зүйлийг хугацаа алдахгүйгээр хамгийн бага үнээр олж авна гэсэн үг. Худалдан авах ажиллагаа нь засгийн газрын байгууллагуудын гүйцэтгэж буй ажил үргийг бодитоор харуулдаг.



PUBLIC PROCUREMENT

Government procurement is the acquisition of goods, services, and public works in a timely manner that results in best value to the government and the people. The performance criterion for evaluating procurement activities is economy, i.e., acquisition at the lowest price without sacrificing quality and timely delivery. Public procurement gives substance to the tasks of government.

Эх сурвалж: Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг



БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

“САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (2023–2030)” БАТЛАГДАВ.

“Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх нь улс орны санхүүгийн салбарын тогтвортой байдал, эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлж, олон улсын санхүүгийн системд аюул заналхийлэл учруулах эрсдэлтэй байдаг. Иймд дэлхийн улс орнууд Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)–аас гаргасан техник хэрэгжилтийн 40



Зөвлөмж болон үр дүнтэй байдлын 11 Шууд хэрэгжилтийн шалгуурыг хангаж ажиллах замаар уг эрсдэлээс урьдчилан сэргийлж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх тогтолцоог бэхжүүлэн ажилладаг.

Монгол Улсын хувьд Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс хийх дараагийн Харилцан үнэлгээнд бэлтгэх, 2017 онд хийгдсэн Харилцан үнэлгээ болон Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээгээр илэрсэн эрсдэл,

эмзэг байдлыг бууруулах зорилго бүхий ФАТФ–ын зөвлөмжид нийцсэн үндэсний бодлого, хөтөлбөрийг боловсруулах шаардлага үүссэн. Энэ ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 7 дугаар сарын 05–ны өдрийн 265 дугаар тогтоолоор “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”–ийг баталсан ба Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд холбогдох саналыг солилцож, идэвхтэй хамтран ажиллаж байна.

Тус хөтөлбөр нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх тогтолцоог олон улсын стандарт, зөвлөмжид нийцүүлэн боловсронгуй болгох зорилготой бөгөөд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбогдох эрсдэлийн ойлголтыг сайжруулах, гадаад болон дотоод хамтын ажиллагааг бэхжүүлэх, эрсдэлд суурилсан бодлого, арга хэмжээ авч хэрэгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөнгө угаах үйлдлийг илрүүлэх ажиллагааг сайжруулах, чадавхыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд батлагдсан.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо

бэхжиж, эдгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа амжилттай хэрэгжиж, улс орны эдийн засгийн хөгжил, санхүүгийн салбарын тогтвортой байдалд эерэг нөлөө бүхий үр дүнтэй юм.

“Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”



Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудын үүрэг оролцоог тодорхойлох, 2030 он хүртэлх баримтлах урт хугацааны бодлого, стратегийг төлөвлөх хүрээнд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулагдсан ээлжит 2 дугаар хуралдаанаар “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх



арга хэмжээний төлөвлөгөө”-г хэлэлцэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/04 тоот тушаалаар баталсан.

Тус төлөвлөгөө нь нийт 194 ажлаас бүрдэх бөгөөд үүнээс 126 ажил үүргийг буюу нийт ажлын 65 хувийг Санхүүгийн зохицуулах хороо үндсэн болон хамтран хэрэгжүүлэгчээр гүйцэтгэхээр заасан.

Иймд, тус төлөвлөгөөнд тусгагдсан Санхүүгийн зохицуулах хорооноос хамаарах ажил үүргийн хэрэгжилтийг хангаж, зохицуулалттай салбарын эрсдэлд тохирсон бодлогын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, дараагийн шатны харилцан үнэлгээнд бэлтгэх зорилго бүхий төлөвлөгөө боловсруулах шаардлага үүссэн.

“Санхүүгийн зохицуулах хорооноос Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2023–2030)”

“Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” батлагдсантай холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 54 дүгээр тогтоолоор “Санхүүгийн зохицуулах хорооноос Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2023–2030)”-г баталсан бөгөөд тус төлөвлөгөө нь нийт 8 зорилго, 40 зорилтын хүрээнд боловсруулагдсан.

Энэхүү төлөвлөгөөг баталснаар хөтөлбөрт тусгагдсан ажил үүргийн биелэлтийг хангах, үр дүнтэй хэрэгжүүлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг сайжруулж, мэдээлэл солилцох, хянан шалгах, дүн шинжилгээ хийх ажлын үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх зэрэг ач холбогдолтой юм. Түүнчлэн, Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын салбар, тэдгээрийн үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний цар хүрээ жил ирэх тутам өргөжин тэлж буй тул Санхүүгийн зохицуулах хорооны цаашдын баримтлах бодлогын чиг хандлага нь Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой байна.

Тус төлөвлөгөөнд тусгагдсан гол ажлуудад траст болон компанийн үйлчилгээ үзүүлэгчид, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчид болон тэтгэврийн сан, даатгалын сангуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх, бага эрсдэлтэй мэдээлэх үүрэгтэй этгээдийг холбогдох үүргээс хэсэгчлэн чөлөөлөх боломжийг судлах, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдох эрсдэл, хүлээх үүрэг хариуцлага, мэдээлэх үүргийг таниулах, ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх ажлыг төлөвлөж хэрэгжүүлэх зэрэг ажлууд багтаж байна.

Цаашид, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх үүднээс Санхүүгийн зохицуулах хороо “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2023–2030)”-нд тусгагдсан ажил үүргийг холбогдох төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд үр дүнтэй хэрэгжүүлж, хяналт тавин ажиллана.



ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

“НОГООН БОНД”-ООР ДАМЖУУЛЖ БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР САНХҮҮЖҮҮЛЭХ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ ТАЛААР ХЭЛЭЛЦЛЭЭ



“Тогтвортой санхүүжилтийн долоо хоног 2023” буюу “Ногоон санхүүжилт-Олон улсын чуулган”-ы хүрээнд “Ногоон бонд” хэлэлцүүлэг боллоо.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан хэлэлцүүлгийг нээж хэлсэн үгэндээ “Сүүлийн жилүүдэд манай улсын хөрөнгийн зах зээл идэвхжиж, УИХ, Засгийн газар болон Санхүүгийн зохицуулах хорооноос хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүд мөн дэд бүтцийн байгууллагууд, хөрөнгө оруулагчдын идэвх оролцоо, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, санхүүгийн олон шинэ бүтээгдэхүүн ар араасаа түүчээлэн гарсны үр дүнд энэ сарын байдлаар зах зээлийн үнэлгээ анх удаа 11 их наяд төгрөгийг давж түүхэн дээд хэмжээнд хүрснийг онцлох нь зүйтэй байна. Санхүүгийн зохицуулах хороо 2021 онд Монголын тогтвортой санхүүжилтийн холбоотой харилцан ойлголцлын санамж бичиг үзэглэж Монгол Улсын санхүүгийн салбар, хөрөнгийн зах зээлийг тогтвортой, ногоон хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан хөгжүүлэх, тогтвортой санхүүжилтийн олон улсын стандартыг нэвтрүүлэх, хариуцлагатай хөрөнгө оруулалт, тогтвортой бизнесийн үйл ажиллагааг дэмжих, чадавхийг бэхжүүлэх хүрээнд хамтран ажилласаар байна. Мөн өнгөрсөн онд болсон “Ногоон санхүүжилт бус нутгийн чуулган”-аар Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн

байгууллагууд “Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг”-ийг баталснаар нээлттэй хувьцаат компаниудыг байгаль орчин, нийгэм, засаглалын тайлан гаргаж мэдээлдэг болох, дотоодын аж ахуй нэгжээс ногоон бонд гаргах замаар байгаль орчинд ээлтэй төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх тогтолцоо бүрдэх чухал ач холбогдолтой алхам болсныг дурдах нь зүйтэй.

Түүнчлэн ногоон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, бодлогын орчныг боловсронгуй болгох, ногоон хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн нэмэгдүүлэх, дотоодын ногоон хөрөнгө оруулалтын оролцоог тэлэх, санхүүгийн зах зээлийн бусад байгууллагуудын ногоон хөрөнгө оруулалтыг нээлттэй болгох зэрэг хөрөнгийн зах зээлийн бодлого боловсруулахад онцгойлон анхаарч ажиллаж байна. Нийтэд санал болгон компанийн бонд гаргах ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн, хялбаршуулж, дотоодын аж ахуйн нэгжүүдийг хямд өртөг бүхий урт хугацааны санхүүжилтийг хөрөнгийн зах зээлээс татах хөшүүргийг бий болгох зорилгоор энэ сарын 11-ний өдрийн ээлжит хуралдаанаар “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ыг баталсан. Ингэснээр дотоодын аж ахуй нэгжүүд олон улсын стандартад нийцсэн “Ногоон бонд”-ыг хөрөнгийн зах зээлд олон нийтэд санал болгон гаргах зохицуулалтын орчин бүрдсэн. Ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор гадаадын эх үүсвэрээс ногоон санхүүжилтийн эх үүсвэр татах хүрээнд “Хаан банк” ХК олон улсын зах зээлд ногоон бонд гаргах ажлыг түүчээлэн эхлүүлснээр тогтвортой эдийн засаг, санхүүжилтийг дэмжсэн түүхэн явдал болж байна. Мөн Хороо “Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн журам”-ын шинэчилсэн найруулгыг батламжилснаар дотоодын аж ахуйн нэгжээс биржийн бус зах зээл дээр Монгол Улсын “Ногоон таксономи” эсхүл олон улсын холбогдох стандарт, шалгуурт заасан ангилал, шалгуурын дагуу ногоон, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор ногоон бонд гаргах нарийвчилсан зохицуулалтын орчин бүрдсэнийг дуулгахад таатай байна. Ногоон хөрөнгө оруулалтын төрлийн шинэ бүтээгдэхүүн нэмэгдсэнээр дотоодын хөрөнгийн зах зээл тэлэх, ногоон санхүүгийн урсгал нэмэгдэх, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах нөгөөтэйгүүр Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг өргөжүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна” гэв.

“РЕАЛТОРУУДЫН ДУУ ХООЛОЙ ФОРУМ-2023” БОЛЛОО



Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан форумыг нээж “УИХ–аас Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулснаар үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамааруулж зохицуулах, хяналт тавих үүргийг хороо хэрэгжүүлэхээр хуульчилсан. Энэ дагуу тусгай зөвшөөрөлтэй нийт 317 аж ахуйн нэгж үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхэлж байна. Үл хөдлөх эд хөрөнгийн зуучлалын үйл ажиллагаа нь мэргэжлийн ур чадварт суурилснаараа онцлогтой. Иймээс мэргэжилтнүүдээ мэргэшүүлэх, чадавхжуулах, ёс зүйн зарчмыг бүрдүүлэх зорилгоор Үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхлэгчдийн дээвэр холбоотой хамтран холбогдох сургалтыг зохион байгуулаад багагүй хугацаа болж байна. Түүнчлэн салбарын оролцогчдын нийгэмд эзлэх байр суурийг бэхжүүлэх, хариуцлагажуулах хүрээнд холбооны санаачлагаар үл хөдлөх хөрөнгийн брокер, агентыг Үндэсний ажил мэргэжлийн стандартад хамруулан индексжүүлж батлууллаа. Ингэснээр салбарын мэргэжилтнүүд буюу брокер, агентуудын нийгэмд эзлэх байр суурийг бататгах томоохон алхам болж чадлаа. Үүний зэрэгцээ Санхүүгийн зохицуулах хороо зохицуулагч байгууллагын хувьд салбараа олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх, тохирсон бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж, хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалахад анхаарч, холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран ажилласаар байна. Энэ зах зээлийг зөв гольдрилоор хөгжүүлж чадвал орон сууцны эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэх бүрэн боломжтой. Ингээд Монголын үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх, салбарын мэргэжилтнүүд болох брокер, агентуудын хоорондын уялдаа холбоог хангах, туршлага солилцох зорилгоор зохион байгуулж буй форумын үйл ажиллагаанд амжилт хүсье” гэсэн юм.

Гурав дахь жилээ болж буй тус форум хоёр хэлэлцүүлгээс бүрдсэн бөгөөд эхнийх нь салбарын бодлого, хамтын ажиллагааны хүрээнд өрнөв. Харин удаах нь АНУ–д төвтэй Үндэсний реалторуудын холбооны Ази номхон далайн бүсийн дэлхийн зохицуулагч, Монгол Японыг хариуцсан төлөөлөгч, Вашингтоны реалторуудын холбооны ерөнхийлөгч зэрэг гадаадын зочид төлөөлөгч оролцож холбооны дэлхий дахинд ажиллаж буй гишүүддээ үзүүлж буй дэмжлэг, үйл ажиллагаа, реалторуудын олон улс дахь үл хөдлөх эд хөрөнгийн салбарт үзүүлж буй нөлөөлөл, боломжийн талаар танилцууллаа.

МОНГОЛ УЛС ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН САНХҮҮЖИЛТИЙН ТАКСОНОМИГ БАТАЛСАН ДЭЛХИЙД АНХДАГЧ УЛСУУДЫН НЭГ БОЛЛОО



“Ногоон санхүүжилт–Олон улсын” чуулсан гурав дахь өдрөө Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Сангийн сайд Б.Жавхлан, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирал С.Баатарсүрэн нар Монгол Улсын “Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономи” –ыг баталлаа.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ “Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс хойш Санхүүгийн зохицуулах хороо урт хугацааны тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, ногоон хөрөнгийн зах зээлийг бий болгох, олон улсын санхүүгийн зах зээлд өргөн хүрээнд ашиглаж буй ногоон бонд гаргах зохицуулалтын орчныг бий болгох хүрээнд ТОС холбоо, Олон улсын санхүүгийн корпораци /IFC/, Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг /AFI/, Европын сэргээн босголт хөгжлийн банк /EBRD/ зэрэг олон улсын байгууллагатай хамтран ажилласан. Энэ хугацаанд олон нийтэд санал болгон компанийн бонд гаргах ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн хялбаршуулж, банкны богино хугацаат, өртөг өндөр зээлийн оронд хөрөнгийн зах зээл

дээрээс санхүүжилт татах зохицуулалтын орчныг боловсронгуй болгохоор “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ыг баталсан. Ингэснээр Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн түүхэнд анх удаа олон улсын жишигт нийцсэн “ногоон бонд” гарах боломж бүрдсэн. Мөн Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс “Ногоон таксономи”-ыг баталснаар ногоон таксономи дахь ангилал, үйл ажиллагааны дагуу анхны ногоон бонд, даатгалын бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалтын сангууд бий болсон” гэдгийг онцолсон юм.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО ОРОН НУТГУУДАД ЗОХИОН БАЙГУУЛАХ ЭНЭ ОНЫ СУРГАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭ ДАРХАН-УУЛ АЙМГААС ЭХЛҮҮЛЛЭЭ



Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжлийг дэмжихэд иргэдийн санхүүгийн мэдлэг боловсрол, оролцоо чухал үүрэгтэй. Ийм ч учраас Санхүүгийн зохицуулах хороо иргэд, олон нийтэд санхүүгийн боловсрол, мэдлэг түгээх сургалт хэлэлцүүлгийг 2013 оноос хойш жил бүр уламжлал болгон зохион байгуулсаар ирсэн. Харин ковидын цар тахал, хөл хорионы улмаас өнгөрсөн гурван жил зохион байгуулж чадаагүй. Иймээс энэ жилээс сургалт хэлэлцүүлгээ хойд бүсийн аймаг болох Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ аймгаас эхлүүлэхээр Дархан-Уул аймагт энэ 5 дугаар сарын 29-ний өдөр нээлтээ хийлээ.

Нээлтийн арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, УИХ-ын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Б.Баттөмөр болон уг арга хэмжээнд хамтран оролцож буй Монгол

үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Монголын хөрөнгийн бирж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, банк, үнэт цаас болон даатгалын компаниуд, банк бус санхүүгийн байгууллагууд, хадгаламж зээлийн хоршооны удирдлагууд, холбогдох мэргэжилтнүүд, аймгийн иргэд, олон нийт оролцлоо.

Сургалт, хэлэлцүүлгийн үеэр Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгийн зах зээлийн бодлого зохицуулалт, өнөөгийн нөхцөл байдал, Хорооны зохицуулалтад шинээр ороод буй мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрхзүйн орчин, зах зээлийн нөхцөл байдал мөн даатгалын салбарын хууль эрхзүйн орчны шинэчлэлт, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, иргэд, олон нийтэд тулгардаг нийтлэг асуудал, санхүүгийн залилан, луйвраас хэрхэн сэргийлэх

талаар мэдээлэл хүргэж, иргэдийн санал асуултад хариулт өглөө. Түүнчлэн Төрийн банкны гүйцэтгэх захирал Ө.Гантөр, Хаан банкны гүйцэтгэх захирал Р.Мөнхтуяа нар банкуудынхаа талаар болон олон нийтэд хувьцаагаа санал болгон арилжаалах үйл ажиллагааны нөхцөл байдлын талаар, Хөрөнгийн биржийн Хяналт, зохицуулалтын газрын захирал А.Мөнхбаясгалан төрийн өмчит компаниудын хувьчлалын үйл ажиллагааны талаар тус тус мэдээлэл хүргэж, иргэдийн сонирхсон асуултад хариулт өгөхийн зэрэгцээ банк, даатгал, банк бус санхүүгийн байгууллага мөн хадгаламж зээлийн хоршооны төлөөллүүд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулах, иргэдэд үнэт цаасны данс нээх, хэрхэн хувьцаа эзэмшигч болох, банкуудын хувьцаа гаргалтад оролцох боломжийг бүрдүүлэхэд зөвлөгөө мэдээлэл өглөө.

Сургалт хэлэлцүүлэг энэ сарын 25-нд Орхон аймагт, энэ сарын 27-нд Сэлэнгэ аймагт тус тус үргэлжилнэ.

БАЙР СУУРЬ

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөнтэй ярилцлаа.

Эхлэл нь 1-р нүүрт



Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль батлагдаж, энэ оноос нүүрсийг цахимаар арилжаалж эхэлсэн. Үүнтэй холбогдуулж Санхүүгийн зохицуулах хорооноос ямар бодлогын арга хэмжээ авч ажиллаж байгаа вэ?

Улсын Их Хурлаас Уул уурхайн бүтээгдэхүүний үнийг шударгаар тогтоох, борлуулалтыг нээлттэй, зах зээлийн зарчимд нийцсэн байдлаар хийх зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний экспортын арилжааг ил тод, нээлттэй болгох зорилгоор Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталсан. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлнэ. Тус хуульд уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаанд төрөөс тавих хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэгч байгууллага нь Санхүүгийн зохицуулах хороо байна гэж заасан. Үүнтэй холбоотойгоор уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, төлбөр тооцооны бэлэн байдлыг хангаж, тус хуульд заасан журмын төслүүдийг хамтран боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг 2023 оны 03 дугаар сард Санхүүгийн зохицуулах хорооны даргын тушаалаар дэд

бүтцийн байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулан баталсан бөгөөд тус ажлын хэсгийн хүрээнд төлөвлөгөөний дагуу холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэн ажиллаж байна.

Санхүүгийн Зохицуулах Хорооны зүгээс Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд тус тус заасан холбогдох журмууд болох “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн болон биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”, “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа төлбөр, тооцоо хийх ерөнхий журам”, “Үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргагчид тавих нөхцөл, шаардлага, шалгуур болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт, түүнийг арилжих журам”-ыг тус тус эцэслэн боловсруулж 2023 оны 6 дугаар сарын 02-ны өдөр тус Хорооны ээлжит хуралдаанаар хэлэлцэж баталсан. Дээрх журмуудыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлээд байна.

Мөн “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны болон ханшийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах, мэдээллийг нийтэд хүргэх журам”-ыг боловсруулж, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан тушаалаар баталсан.

Эдгээр журмуудыг баталснаар бирж болон брокерийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг зохион байгуулах, арилжаанд зуучлах үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргах нөхцөл бүрдэж, арилжаа, төлбөр, тооцоо, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэгч талуудын үүрэг, хариуцлага тодорхой болохын зэрэгцээ уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа олон улсын жишгийн дагуу шударга, ил тод, нээлттэй явагдах суурь эрх зүйн орчин бүрдээд байна.

Түүнчлэн “Монголын хөрөнгийн бирж” ХК-аас хуульд заасан холбогдох журмын төслүүдийг боловсруулан ажиллаж байгаа бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс шаардлагатай санал, зөвлөмжийг тухай бүр өгч ажиллаж байна.

Саяхан Монголын хамгийн анхны ногоон бонд бүртгэгдлээ шүү дээ. Энэ бүтээгдэхүүний давуу тал, ач холбогдлын талаар яриач.

Санхүүгийн зохицуулах хорооноос ногоон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, бодлогын орчныг боловсронгуй болгох, ногоон хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн нэмэгдүүлэх, дотоодын ногоон хөрөнгө оруулалтын оролцоог тэлэх, санхүүгийн зах зээлийн бусад байгууллагуудын ногоон хөрөнгө оруулалтыг нээлттэй болгох зэрэг хөрөнгийн зах зээлийн бодлого боловсруулах тал дээр онцгой ач холбогдол өгч ажиллаж байна. Тухайлбал Санхүүгийн зохицуулах хорооноос нийтэд санал болгон компанийн бонд гаргах ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн, хялбаршуулж, дотоодын аж ахуйн нэгжүүдийг хямд өртөг бүхий урт хугацааны санхүүжилтийг хөрөнгийн зах зээлээс татах хөшүүргийг бий болгох зорилгоор 2021 онд “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ыг шинээр баталсан. Тус журамд ногоон бонд гаргах бонд гаргагч нь санхүүгийн чадавхын зэрэглэл тогтоолгосон бол барьцаагүйгээр бонд гаргах зохицуулалтыг тусгасан. Ингэснээр ногоон бонд гаргахад тодорхой үнийн дүн бүхий бондуудыг бүхэлд нь нэг удаа бүртгүүлж тэдгээрийг нэг удаа, эсхүл хэд хэдэн удаа хэсэгчлэн санал болгож, шаардлагатай санхүүжилтийг татах нөхцөлийг бүрдүүлж өгсөн юм.

Үүний хүрээнд 2023 оны 6 дугаар сарын 12-ны өдөр ХААН банкны гаргаж буй ногоон бондыг Санхүүгийн зохицуулах хороо бүртгэсэн нь Монголын хөрөнгийн зах зээл дээр бүртгэгдэж буй анхны ногоон бонд болсон бөгөөд энэ нь тогтвортой эдийн засаг, санхүүжилтийг дэмжсэн түүхэн явдал болсон билээ. Энэхүү бонд нь олон улсын “Sustainable Fitch” байгууллагаар ногоон бондын зарчмуудтай нийцсэн талаарх дүгнэлт гаргуулсан гэдгээрээ онцлогтой.

Ногоон хөрөнгө оруулалтын төрлийн шинэ бүтээгдэхүүн нэмэгдсэнээр дотоодын хөрөнгийн зах зээл тэлэх, ногоон санхүүгийн урсгал нэмэгдэх, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах нөгөөтээгүүр Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг өргөжүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Хөрөнгийн зах зээл алсдаа хэрхэн хөгжих төлөвтэй байна вэ?

Сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээл асар хурдтайгаар хөгжиж байна. Үүнд Улсын Их Хурал, Засгийн газар болон Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс хэрэгжүүлж буй бодлого зохицуулалтын олон арга хэмжээнүүд, мөн дэд бүтцийн байгууллагууд, хөрөнгө оруулагчдын идэвх оролцоо, төр, хувийн хэвшлийн нягт хамтын ажиллагаа болон зах зээл дээрх олон шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн ар араасаа гарч буй зэрэг чухал нөлөө үзүүлсэн нь энэ үр дүнд хүрэхэд голлох нөлөө үзүүлсэн болов уу гэж бодож байна.

Цаашид Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгийн зах зээлийн эдийн засагт гүйцэтгэх үүрэг оролцоог улам нэмэгдүүлж, бүс нутгийн болон олон улсад хэмжээнд өрсөлдөхүйц түвшинд хүргэх, өнөөгийн өндөр өсөлт, амжилтыг хэвээр хадгалан хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн тулд Үнэт цаасны зах зээлийн хууль эрх зүйн орчныг шинэчлэх, хөрөнгийн зах зээлийн шинэ бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, дэд бүтцийн системийн уялдаа холбоог сайжруулж, үйл ажиллагааны үр ашигт байдлыг нэмэгдүүлэх, төрийн өмчит компаниудыг биржээр дамжуулан хувьчлах, ТОП-100 ААН-үүдийг хөрөнгийн зах зээлд IPO хийх, компанийн бонд гаргахад тавих нөхцөл, шаардлагыг бууруулж, үнэт цаас гаргах ажиллагааг хялбаршуулах зэрэг бодлогын шат дараалсан арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Түүнчлэн гадны томоохон мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг Монгол Улсын хөрөнгийн зах зээлд оролцох идэвх сонирхлыг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд олон улсын хөрөнгийн зах зээлийн интеграцид нэгдэх, гадаадын болон дотоодын компаниудын давхар бүртгэл, шууд бүртгэлийн хялбаршуулсан горимыг нэвтрүүлэх, хадгаламжийн бичиг (Depository receipt) гаргах, үнэт цаасны танилцуулга болон бусад мэдээллийг англи хэл дээр гаргах, түгээх чиглэлд олон улсын зохицуулагч байгууллагуудтай хамтран Монголын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зэрэг ажиллагаа хүлээгдэж байна.

ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

“МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ”-ЫН ТАЛААР

Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа нь тодорхой нэр төрлийн эд хөрөнгө барьцаалан зардал чирэгдэл багатайгаар түргэн шуурхай бичил зээлийн үйлчилгээг хүргэдэг иргэдийн дунд хамгийн өргөн дэлгэрсэн санхүүгийн бус үйлчилгээний нэг төрөл тул ФАТФ (Санхүүгийн хориг арга хэмжээг авах байгууллага)-ын зөвлөмжөөр барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхлэгчдийг мэдээлэх үүрэг бүхий этгээдээр тодорхойлохыг зөвлөсөн байдаг.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн 2.4.3–т “Барьцаалан зээлдүүлэх газар, иргэнээс олгох зээлийн үйл ажиллагааг бүртгэл хяналттай болгож, мөнгө хүүлэлтийг тодорхойлох эрх зүйн зохицуулалтыг бий болгох, Монгол Улсын Засгийн газрын 2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийг боловсруулах гэж тус тус тусгагдсаны дагуу Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 11 дүгээр сарын 04–ний өдөр Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг баталсан бөгөөд тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 11 дүгээр зүйлийн 11.10, 11.12–д заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 03 дугаар сарын 13–ны өдрийн 81 дүгээр тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам”-ыг баталсан бөгөөд тус журамд дараах харилцааг зохицуулсан. Үүнд:

1. Нийтлэг үндэслэл:

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам” нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд, байнга, ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэнээр бүртгүүлэх өргөдөл гаргагчийг бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлтэй этгээдийн үйл ажиллагаанд

тавигдах шаардлагыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2. Өргөдөл гаргагчид тавигдах шаардлага:

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 5.1–д мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон бөгөөд журмын 2.1 дэх хэсгээр хуульд зааснаас гадна дараах шаардлагыг өргөдөл гаргагч хангасан байхыг журамласан. Үүнд:

- ◆ Мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь баримтаар тодорхойлж, нотлох боломжтой хууль ёсны орлого байх,
- ◆ Цахим мэдээллийн санд мэдээлэл илгээх, хүлээн авах, дотоод бүртгэл мэдээллийг хөтлөх боломжтой компьютер, техник, тоног төхөөрөмжтэй байх,
- ◆ Хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан дуу–дүрсний бичлэгийн төхөөрөмжийг аюулгүй байдал хангах зорилгоор ажлын байранд байршуулсан байх.

Дээрх шаардлагыг хангаснаар хууль ёсны мөнгөн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл мэдээллийг цахимжуулж, ил тод болгох, төрийн болон холбогдох бусад байгууллагатай мэдээлэл солилцох мэдээлэл дамжуулж, хүлээн авах боломжтой цахим системд холбогдсоноор гэмт халдлага, зөрчлөөс сэргийлэх, үйл ажиллагаа явуулах аюулгүй байдлыг хангах суурь нөхцөл бүрдэнэ.

3. Өргөдөл гаргагчийг бүртгэх, бүртгэхээс татгалзах

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль болон журмаар тогтоосон шаардлагыг хангасан өргөдөл, хүсэлтийг цахимаар хүлээн авах, хуульд заасан хугацаанд хянаж, шийдвэрлэх, бүртгэх, бүртгэхээс татгалзах, бүртгэлийн цахим санд бүртгэх үйл ажиллагааны дарааллыг журамлан зохицуулсан.

4. Бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлтийг бүртгэх

Журмын 4–6 дугаар бүлэгт Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлсэн хөрөнгө, мөнгөн хөрөнгийн хэмжээг өөрчлөх, салбар, оноосон нэр өөрчлөх, гүйцэтгэх удирдлага, менежер, хаяг байршилд өөрчлөлт оруулах зэрэг бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулахтай холбогдсон харилцааг зохицуулсан бөгөөд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг анх бүртгэсэн бүртгэлийн байгууллага хуульд заасан хугацаанд хянаж, бүртгэлдээ өөрчлөлт оруулахаар зохицуулсан.

5. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд цахимаар зээл олгох

Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд дэвшилтэт технологийн шийдэл ашиглан цахимаар зээлийн бүтээгдэхүүн гаргах тохиолдолд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 2,500,000,000 /хоёр тэрбум таван зуун сая/ төгрөгөөс доошгүй байх, мэдээллийн аюулгүй байдлын ISO/IEC 27001 стандарт, кибер аюулгүй байдлын холбогдох стандартыг хангасны үндсэн дээр цахим зээл олгохоор зохицуулсан.

6. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үйл ажиллагаа

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд үйл ажиллагаа хэвийн, тогтвортой явуулахад шаардагдах үйл ажиллагаандаа баримталбал зохих хэм хэмжээг тогтоож өгсөн бөгөөд энэ нь мэдээллийн үнэн зөв найдвартай байдлыг хангах, харилцагч үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах, барьцаа хөрөнгийн найдвартай, аюулгүй байдлыг хангах, мөнгө угаах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн.

7. Бусад


Бүртгэх байгууллагын мэдээлэл шаардах эрх, холбогдох бүртгэлийг цахим системээр дамжуулан бүртгэх харилцаанаас гадна үйл ажиллагаа нь доголдож, түдгэлзүүлсэн этгээдийн үйл ажиллагааг сэргээх, түдгэлзүүлсэн шийдвэр нь мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдох үйл ажиллагааг хязгаарлахгүй болохыг зохицуулж өгсөн.



ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

НҮҮРСХҮЧЛИЙН ХИЙН ЯЛГАРЛЫН ҮНЭ ТОГТООХ БА ТҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙГ ҮҮСГЭХ

Улс орнууд нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулах Киотогийн протоколд туссан амлалтаа Үндэсний тодорхойлсон хувь нэмэрт оруулсан зорилтдоо тусгасан. Үүний тулд Парисын хэлэлцээрийн 6 дугаар заалтын дагуу нүүрсхүчлийн хийн /Карбон/-ны зах зээлд карбоны кредитийг арилжих замаар өртөг багатайгаар хэрэгжүүлж, зорилтот хэмжээндээ хүрч байна.



Карбоны зах зээл нь карбоны кредитийг худалдаж, худалдан авдаг арилжааны систем ба компани, хувь хүн оролцож карбоны кредитийг худалдан авснаар карбон ялгарлын бууралтад хувь нэмэр оруулдаг.

Одоогийн байдлаар комплайнсын ба сайн дурын гэсэн хоёр төрлийн зах зээл байна. Комплайнсын зах зээл нь үндэсний, бүс нутгийн болон олон улсын бодлого, зохицуулалтын шаардлагаар байгуулагддаг. Харин сайн дурын карбон зах зээл нь үндэсний болон олон улсын түвшинд карбон кредитийг гаргаж арилжих сайн дурын үндсэн дээр байгуулагддаг.

Европын холбоо 2005 онд анхны олон улсын карбоны арилжааны системийг гаргасан бол 2021 онд Хятад улс дэлхийн хамгийн том арилжааны системийг гаргаж байсан. Түүнээс хойш маш олон системүүд хөгжүүлэлтийн үе шатандаа явж байна.

Европын холбооны хувьд карбоны зах зээлийн хөгжлийн гурван үе шатыг дамжсан. Үүнд:

Хөгжлийн нэгдүгээр үе шат (2005–2007): Хөгжлийн хоёрдугаар үе шатанд бэлтгэсэн ба цахилгаан станцууд болон эрчим хүч ихээр хэрэглэдэг үйлдвэрүүдэд төвлөрсөн. Ингэхдээ карбон хэрэглээг бууруулаагүй нөхцөлд тонн тутамд 40 еврогийн торгууль оногдуулсан. Энэ үе шатанд карбоны үнэ тогтоох, карбон ялгаруулалтын кредитийн чөлөөт арилжаа болон дэд бүтцийг бий болгосон.

Хөгжлийн хоёрдугаар үе шат (2008–2012): Тус үе шатанд Исланд, Норвег, Лихтенштайн улсууд шинээр нэгдсэн. Торгуулийн хэмжээ тонн тутамд 100 евро болж өссөн.

Хөгжлийн гуравдугаар үе шат (2013–2020): Гуравдугаар үе шатанд өмнөх хоёр үетэй харьцуулахад нэлээд өөрчлөлт хийгдсэн. Үндэсний түвшинд хийгддэг байсан арилжаа Европын улс орон даяар хийгдэх болсон. Үүнд эдийн засгийн олон салбар нэмэгдсэн.



Европын холбоо нь Киотогийн протокол дахь амлалтандаа хүрэхээр үүсгэсэн карбон зах зээл нь маш эрчимтэй хөгжсөн ба карбон зах зээл дээрх арилжааны хэмжээ 2008

оны 3.1 тэрбум тонноос 2012 онд 7.9 тэрбум тонн болж өссөн нь олон улсын карбон зах зээлийн 84 хувийг бүрдүүлсэн. Цаашид шийдвэрлэхээр тулгараад буй асуудал нь карбон зах зээлийн хэлцэлд ил тод байдлыг хангах явдал юм.

Европын холбооноос карбон зах зээлийн хөгжлийн дөрөвдүгээр үе шатыг 2021–2030 оны хооронд тодорхойлсон ба ирэх 10 жилд зах зээлээ тэлэх бодлого баримталж байна. Үүнд агаар мандлаас бууруулсан карбоны тонн тутмыг төлөөлөх санхүүгийн хэрэгслийг олон улсад арилжих, зах зээлийн ил тод байдлыг хангах, зах зээлийн гажуудал гарахаас сэргийлэх, ёс зүйг мөрдүүлэх зэрэг зорилтууд багтсан.

Үүнээс дүгнэхэд карбоны кредитийг арилжих карбоны зах зээл нь санхүүгийн зах зээлийн нэг хэсэг, нэгэн төрлийн санхүүгийн хэрэгсэлд хамаарч байгаа юм.

ФИНТЕК БА РЕГТЕК

МОНГОЛ УЛСЫН БИЧИЛ САНХҮҮГИЙН САЛБАРЫН ФИНТЕК ҮЙЛЧИЛГЭЭ


Монгол Улсад 2008 онд “Мост Финтек” ХХК үндэсний хэмжээний цахим төлбөр тооцооны платформ бий болгох зорилгоор байгуулагдаж байсан. 2012 онд Худалдаа, хөгжлийн банк мобайл банкны төсөл хэрэгжүүлж Мост мони үйлчилгээг зах зээлд нэвтрүүлсэн. Үүнээс хойш QR уншуулах байдлаар төлбөрийн үйлчилгээ явуулах боломж бүхий Qpay, цахим хаяг болон утасны дугаар ашиглан төлбөрийн үйлчилгээ үзүүлэх Socialpay зэрэг олон финтекүүд нэвтэрсэн. 2017 оноос финтек зээлийн үйлчилгээг нэвтрүүлж эхэлсэн бөгөөд өнөөгийн байдлаар нийт финтек зээлийн үйлчилгээ үзүүлж байгаа ББСБ-ын тоо 39-д хүрээд байна. Мөн хэд хэдэн ББСБ-ууд төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээг технологи ашиглан хүргэж байгаа юм. Технологийн дэвшилд тулгуурласан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх болсноор бидний өдөр тутмын амьдралын хэв маяг өөрчлөгдөөд зогсохгүй, түргэн шуурхай хямд өртөг бүхий нийгмийн аль ч бүлэгт газар зүйн байршлаас үл хамааран хүрч үйлчлэх санхүүгийн бүтээгдэхүүнийг авч хэрэглэх боломж бүрдэж, цаашлаад энэ нь нийт эдийн засагт санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх томоохон хөшүүрэг болж байгаа юм. Нөгөө талдаа финтек компаниуд санхүүгийн зах зээлд

орж ирснээр уламжлалт санхүүгийн байгууллагуудын бүтцийн зардал буурах, бүтээгдэхүүн үйлчилгээний чанар сайжрах, бизнесийн үр ашигтай шинэ загвар бүрэлдүүлэх зэрэг олон эерэг хандлагууд гарч ирсээр байна.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-ууд нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заагдсан 9 төрлийн тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаанаас зээлийн үйл ажиллагаа болон цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээг финтек ашиглан үзүүлж байгаа юм.


Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 514 ББСБ 9 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 93.2 хувь буюу 477 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 59.3 хувь буюу 305 ББСБ дагнан эрхэлж байна. Түүнчлэн сүүлийн 5 жилийн хугацаанд финтек зээлийн үйлчилгээ үзүүлж байгаа ББСБ-уудын тоо тогтмол өссөөр 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 477 зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ББСБ-аас 39 нь финтекээр зээл олгож байна.

Зураг. Финтек зээлийн үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-ын тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Зураг. Монгол Улсын ББСБ–ын нийт харилцагчид болон финтек харилцагчдын тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дээрх графикаас харахад ББСБ–ын салбарын нийт харилцагчдын 80–95 хувийг финтек харилцагчид эзэлж байна. Мөн Банк бус санхүүгийн салбарт финтек зээлийн үйлчилгээг хөгжүүлснээр иргэд техник технологийг ашиглаж барьцаа хөрөнгө шаардахгүй, богино хугацаатай, бага хэмжээний зээлийг тусгай зөвшөөрөлтэй, төрийн зохицуулалттай, мэргэжлийн ББСБ–аас хялбар, түргэн шуурхай, нөхцөл багатайгаар авч байгаа нь тухайн салбарын нийт зээлдэгчдийн тоог өсгөх хандлагатай байна.


Зураг. Монгол Улсын ББСБ–ын нийт зээлдэгчид болон финтек зээлдэгчдийн тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт зээлдэгчдийн дүнд эзлэх финтек зээлдэгчдийн тоо харьцангуй өндөр байгаа боловч нийт зээлд эзлэх финтек зээлийн дүн бага байгаа нь финтекээр олгож байгаа зээлийн хэмжээ бага байдагтай холбоотой юм.

Зураг. Монгол Улсын ББСБ–ын нийт зээл болон финтекээр олгож байгаа зээлийн хэмжээ /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт зээл 2.9 их наяд төгрөг байгаа бол үүнээс финтекээр олгосон зээлийн дүн 0.6 их наяд төгрөг, 1 зээлдэгчид ногдох дундаж зээлийн хэмжээ уламжлалт зээлд 7.4 сая төгрөг байгаа бол финтек зээлд 0.6 сая төгрөг байгаа нь финтек зээлийн хэмжээ бага дүнтэй байгааг харуулж байна.

СУДЛААЧИЙН ИНДЭР

ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖ БА ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛИЙН АРИЛЖААГ БИЙ БОЛГОХ НЬ

/ХУРААНГУЙЛСАН/

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ХУРААНГУЙ

Хөрөнгийн зах зээлд уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг эхлүүлэхэд түүний бүтэц, зохион байгуулалт, эрхзүйн орчин болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааг явуулах гэрээний стандарт, эрхзүйн орчныг бүрдүүлэхэд энэхүү судалгааны зорилго оршино.

УДИРТГАЛ

Түүхий эдийн арилжаа нь бартерын системээс спот зах зээл рүү үүсмэл хөрөнгийн зах зээл хүртэл олон зууны турш хөгжиж ирсэн. Түүхий эдийн фьючерсийн арилжаа Японд эхэлсэн бөгөөд Осака хотод будааны бирж 1730 онд хамгийн анхны зохицуулалттай фьючерс зах зээлийг байгуулжээ. Улмаар 1848, 1877 онд АНУ-д Чикагогийн худалдааны төв (CBOT), Лондонгийн металлын бирж (LME) тус тус үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Дараагийн хэдэн арван жилд Аргентин, Хятад, Египет, Орос, Унгар, Турк, Энэтхэг зэрэг дэлхийн улс орнуудад илүү олон арилжаа бий болсон. 1990-ээд оноос хойш зах зээлийн зохицуулалт, мэдээллийн технологийн гайхалтай хөгжлийн үр дүнд түүхий эдийн биржүүд дэлхий даяар хөгжиж эхэлсэн.

Манайд Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталж, 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс тус хуулийг мөрдөж эхлэх шийдвэр гарснаар уг бирж эхлэх эрхзүйн орчин бүрдлээ. Уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжих эрхзүйн орчин үүссэнтэй холбоотой олон улсын стандартад нийцсэн санхүүгийн үүсмэл хэрэгслийг арилжих, тухайн бүтээгдэхүүнийг

Гүйцэтгэсэн:

СЗХ-ны ЗЭСХГ-ын ахлах референт Н.Нарантуяа
СЗХ-ны ЗЭСХГ-ын мэргэжилтэн Х.Нинжбадгар
“ҮЦКТ” ХХК-ийн Клиринг эрсдэлийн удирдлагын албаны ахлах мэргэжилтэн А.Бямбажаргал

стандарт хангасан агуулахад хадгалж, тээвэрлэх байдлаар худалдан авагчид чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг хүргэх шат дамжлагуудыг бий болгох хэрэгцээ шаардлага бий болсон. Уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжсанаар худалдан авагчийн итгэлийг нэмэгдүүлэх, гадаадын олон улсаас арилжаанд оролцох, мэдээллийн ил тод байдал сайжрах давуу талуудтай.

Нөгөө талаасаа бирж оролцогч талуудыг хооронд нь зуучилж, тэдгээрийн худалдах, худалдан авах үйл ажиллагаанд итгэл олгож байгаа тул эрсдэлийг удирдах сайн механизм байх шаардлагатай. Иймээс үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээний стандартыг хангах, төлбөр тооцооны эрсдэлийг удирдах, агуулах, тээвэрлэлтийн удирдлагыг зөв хэрэгжүүлэх шаардлагатай.

Түүхий эдийн биржийн онцлог нь үүсмэл санхүүгийн хэрэгслийг худалдан, худалдан авч буй талууд нь цөөн тооны, их хэмжээний арилжааг хил дамнан хийдэг онцлогтой тул олон улсын хэмжээнд, олон талууд ойлгогдохуйц байх шаардлага тавигддаг.

Энэхүү судалгаагаар түүхий эдийн биржийн арилжаа явагддаг үйл явц, оролцогч талуудыг зураглан, тэдгээрийн үүрэг, оролцоог судалж, жишээ болгон Энэтхэг болон Этиопын түүхий эдийн биржийн туршлагыг оруулсан.

Мөн үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээ боловсруулах талаар стандарт, загваруудын талаар тусгасан болно.

ЗАХ ЗЭЭЛИЙН БҮТЭЦ, ОРОЛЦОГЧИД


Худалдан авагч, худалдагч хоёрын хооронд бараа нийлүүлдэг тул таваарын зах зээл нь хөрөнгийн зах зээлээс ялгаатай. Гэрээний хугацаа дууссаны дараа бараа бүтээгдэхүүнийг худалдан авагч болон худалдагчийн хооронд биет байдлаар солилцдог нь агуулах, тээвэр, логистикийн дэд бүтэц, түүний удирдлагыг хэрэгжүүлдэг онцлогтой.

Түүхий эдийн арилжааны оролцогч талууд нь олон улсыг хамардаг тул үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээ нь олон улсын стандартад нийцсэн, бүтээгдэхүүн тус бүрээр ялгаатай байдаг.

Түүхий эд нь гаргасан чанарын шаардлагын дагуу худалдан авагчид хүргэгдэх тул лабораториор түүхий эдийг шинжлүүлж, чанарыг тогтоолгох ба тодорхойлсон чанарыг алдагдуулахгүйн тулд агуулахад хадгалах, тээвэрлэх стандартыг бүтээгдэхүүн тус бүрээр бирж боловсруулан баталж, түүнийг нь зохицуулагч байгууллага батламжлах үүрэгтэй. Бирж түүхий эд тус бүрээр чанарын стандартыг боловсруулдаг байна.

Түүхий эдийн биржийн ажиллах процессыг дараах схемээр зураглалаа.

Зураг. Түүхий эдийн арилжааны бүтэц



Түүхий эд худалдан борлуулагч нь биржийн агуулахын үйлчилгээ үзүүлэгчид бараагаа хадгалуулах ба өмчлөх эрхээ төвлөрсөн хадгаламжийн байгууллагад бүртгүүлж, агуулахын баримт авна. Бирж арилжаа зохион байгуулахдаа худалдагч талын түүхий эдийн үлдэгдлийг, худалдан авагч талын маржин байршуулсан эсэхийг тулгаснаар захиалгыг хүлээн авна.

Худалдагч, худалдан авагч тал аль аль нь биржийн гишүүн брокероор дамжуулан биржид худалдан, худалдан авах захиалга өгнө.

Хэлцэл биелсний дараа клирингийн төв тооцоог гүйцэтгэх ба арилжаанд оролцогчдын аль нэг тал төлбөрөө төлөхгүй байх буюу холбоотой талуудын эрсдэл болон дефолтын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

Клирингийн төвөөс тооцооны мэдээлэл төлбөрийн банк болон агуулахын үйлчилгээ үзүүлэгчид илгээгдэх ба төлбөрийн банк төлбөрийг шилжүүлэх, агуулахын үйлчилгээ үзүүлэгч барааг ачуулах үүрэг хүлээнэ. Үүний дараа төвлөрсөн хадгаламжийн байгууллага өмчлөх эрхийг худалдан авагч талд шилжүүлнэ.

Түүхий эдийн бирж нь агуулахын үйлчилгээ үзүүлэгчдийг сонгон шалгаруулж гишүүнээр ажиллуулах ба шалгарсан агуулахууд нь түүхий эдээ биржээр дамжуулж арилжих худалдан борлуулагчдын бараа найдвартай, чанартай хадгалах үүрэг хүлээнэ.

Түүхий эдийг худалдан борлуулагч нь агуулахад бараагаа нийлүүлснээр төвлөрсөн хадгаламжийн байгууллага бүртгэж, өмчлөх эрхийг илэрхийлэх агуулахын баримт өгнө. Хэлцэл биелсний дараа худалдан авагч талаас төлбөр хийгдсэнээр түүхий эдийн өмчлөх эрх худалдан авагч талд шилжинэ.

Худалдагч тал түүхий эдийг тээвэрлэх явцад үүсэх эрсдэлээс хамгаалж даатгалд хамрагдаж болно.

Хэлцэл биелсэн барааг худалдагч талд хүргэхэд тээвэрлэлтийн компаниуд гишүүнчлэлд үндэслэн биржтэй хамтран ажилладаг. Барааг олон улсын арилжааны танхимаас гаргасан incoterm-ын шаардлагыг хангасан стандартчилагдсан контейнерээр тээвэрлэдэг.

Бараа таваарын дериватив гэрээний арилжаа нь барааг хүргэх шаардлагын улмаас үнэ ханшийг зохиомлоор өсгөх эрсдэлд өртөмтгий байдаг. Иймд зах зээлийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх нь чухал байдаг.


Клирингийн төвийн үүрэг: Бусад санхүүгийн зах зээлүүдтэй адил фьючерсийн зах зээлд харилцагчийг зах зээлд хандах боломж олгох, арилжаатай холбоотой төрөл бүрийн үйлчилгээ үзүүлдэг хэд хэдэн төрлийн зуучлагч нар байдаг. Ялангуяа фьючерсийн зах зээлд харилцагч, арилжааны байгууллага, клирингхаус нарын дунд зуучлагчийн үүрэг гүйцэтгэдэг клирингийн байгууллага нь чухал ач холбогдолтой.

Клирингийн байгууллага буюу АНУ-д Future Commission Merchant (FCM), Европт клирингийн ерөнхий гишүүн гэж нэрлэгддэг байгууллага нь фьючерсийн зах зээлийн арилжаа, клирингийн циклд хэд хэдэн чухал үүрэг гүйцэтгэдэг.

- ◆ Харилцагчдад фьючерсийн арилжаа эрхлэх байгууллага, клирингхауст нэвтрэх эрх олгодог;
- ◆ Зах зээл болон харилцагчдыг хамгаалах зорилгоор өргөн хүрээний хяналт, шалгалтыг явуулдаг;
- ◆ Харилцагчдаас маржин цуглуулж, тэдний зах зээлийн гэрээний үүргийн баталгааг гаргаж өгдөг;
- ◆ Клирингхаусын барьдаг дефолтын сангийн томоохон хэсгийг бүрдүүлдэг. Энэхүү сан нь дефолтын үеийн алдагдлыг хаах, зах зээлийн тогтвортой байдлыг хангах үүрэгтэй.

Эдийн засгийн болоод зах зээлийн стресст үед фьючерсийн зах зээлийн бат бөх, уян хатан чанар нь танигдсан. 2008 оны санхүүгийн хямралын үеэр фьючерсийн зах зээлийн үйл ажиллагаа тогтвортой явсаар байсан. Фьючерсийн зах зээлийн стресст нөхцөл байдалд тэсвэртэй байгаа шалтгаан нь зах зээлд ажиллаж байгаа клирингийн байгууллагууд гэж үздэг.

Зураг. Фьючерсийн зах зээлийн үндсэн зураглал



Клирингийн гишүүн болон эрсдэлийн удирдлага:

Клирингийн тогтолцоонд учирч болох хамгийн том эрсдэл бол дефолт. Фьючерсийн гэрээний хөшүүрэг өндөр байдаг тул зах зээлийн гэнэтийн хөдөлгөөн их хэмжээний алдагдлыг үүсгэж болно. Клирингийн гишүүн нь клирингийн тогтолцоо болон зах зээлийн тогтвортой байдалд гол үүргийг гүйцэтгэдэг.

Клирингийн байгууллагын доголдол ховор тохиолддог ба үүнээс шалтгаалж харилцагчид алдагдал үүсэх тохиолдолд бүр ч ховор. Учир нь клирингийн байгууллагын харилцагчдад хийж буй төлбөрийн чадварын хяналт өндөр байдаг.

Клирингийн гишүүн харилцагчдынхаа гэрээний үүргийн хэрэгжилтийг батлан даадаг. Харилцагчийн эзэмшиж буй гэрээний позицод алдагдал үүсэх тохиолдол гардаг учир заавал батлан даах шаардлага үүснэ. Хэрэв харилцагчийн маржин тухайн позицын шаардлагад хүрэлцэхгүй болсон тохиолдолд гэрээг хаах үед үүсэх аливаа алдагдлыг клирингийн гишүүн барагдуулна.

Бүтцийн үүднээс дүгнэн үзвэл клирингийн тогтолцоо нь хэсэглэсэн эрсдэлийн (compartmentalizing risk) нөлөөтэй. Нэг хэсгийн доголдол гэхээсээ илүү клирингийн систем нь клирингийнхаусын гишүүдийн эрсдэлийг нэгтгэн (mutualize) клирингхаус тэр чигтээ доголдохоос сэргийлдэг. Иймд клирингийн гишүүдийн санхүүгийн чадвар нь клирингхаусын найдвартай байдлыг хангадаг.

Олон улсын фьючерсийн зах зээлд клирингийн үйлчилгээ үзүүлдэг ICE Clear Europe байгууллагын эрсдэлийн удирдлагыг жишээ болгон авч үзлээ.

ICE Clear Europe-ийн эрсдэлийн удирдлагын бодлого нь хүчирхэг клирингийн зохицуулалт болон Клирингхаус, клирингийн гишүүдэд учирч болзошгүй эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгахад төвлөрдөг. Дээрх зорилгын дагуу ICE Clear Europe цогц, шаталсан ватерфол хөгжүүлсэн. Үүнд:

Хамгаалалтын шугамууд:

- 1. Гишүүнчлэлийн шалгуур үзүүлэлт:** Клирингийн гишүүн бүр хангалттай хэмжээний санхүүгийн нөөц, үйл ажиллагааны бололцоо, эрсдэлийн удирдлагын туршлагатай байх.
- 2. Хувьсах маржины шаардлага:** Бүх нээлттэй позицууд өдөр бүр зах зээлийн үнийн дагуу явна. Позицын ашиг алдагдал (P&L) өдөр бүр гэрээнд заасан валютын дагуу төлөгдөнө(settled).

- 3. Өдөр тутмын хяналт, Маржин кол:** Клирингийн гишүүдийн позиц өдөр тутам хянагдана. Хувьсах маржины алдагдал эсвэл Анхдагч маржины шаардлагатай дүн өссөн тохиолдолд өдрийн дотор нэмэлт маржин шаардах.
- 4. Маржин шаардлага:** Клирингийн гишүүд нээлттэй позицод хамаарах анхдагч маржин байршуулах шаардлагатай. Анхдагч маржин нь зах зээлийн хэвийн нөхцөл байдалд Клирингийн гишүүн дефолт болсон тохиолдолд үүссэн алдагдлыг нөхөх зориулалттай байна.
- 5. ICE-ийн Анхдагч нөөц:** Өөрийн нөөцийг (skin-in-the-game) санд байршуулна.
- 6. Дефолтын даатгал:** ICE нь Клирингийн гишүүдийн болон ICE-ийн дундын дефолтын сангаас давсан алдагдал үүссэн тохиолдолд ашиглах дефолтын даатгалтай байна.
- 7. Клирингийн гишүүний Баталгааны сан:** Зах зээлийн экстрем нөхцөл байдалд Клирингийн гишүүний анхдагч маржин алдагдлыг хаахад хангалтгүй болсон тохиолдолд алдагдлыг хаах тусдаа (separate) CDS болон F&O Баталгааны сантай байна.
- 8. Хуваарилалтын эрх мэдэл (Power of Assessment):** Клирингийн гишүүний дефолтын алдагдал Баталгааны сангийн хэмжээнээс давсан тохиолдолд хуваарилалтын эрх мэдлийн хүрээнд ICE бусад клирингийн гишүүдээс нэмэлт сан босгох эрх мэдэлтэй байна.
- 9. ССР Нөхөн сэргэлтийн механизм:** Олон дараалсан эсвэл том хэмжээний дефолтоос үүдэн Клирингхаусын нөөц шавхагдах үед хэрэгжүүлэх арга хэмжээ, бодлогыг тодорхойлох.

Маржин тооцоолол: Клирингхаус нь фьючерсийн гэрээний төрөл, онцлогоос шалтгаалан маржины аргачлал, моделийг боловсруулдаг. Түгээмэл ашиглагддаг маржин моделиуд нь түүхэн мэдээлэлд үндэслэдэг. Жишээ нь:

- ◆ Түүхэн симуляцийн арга
- ◆ Параметрик VaR
- ◆ Монте карло симуляци
- ◆ Стресс үеийн симуляци гэх мэт.

Төвлөрсөн хадгаламжийн төв: ЕСХ нь бүтээгдэхүүний бүрэн бүтэн байдлыг баталгаажуулдаг төвлөрсөн хадгаламжийн газар эсвэл агуулахын баримтын бүртгэлийг хөтөлдөг. ЕСХ-ийн агуулахад цахим бараа хүлээн авсан тухай мэдэгдэл нь ЕСХ Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс Цахим агуулахын баримт олгох урьдчилсан нөхцөл юм. ЕСХ Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нь цахим агуулахын баримт гаргах, төлбөрийн баримтын хуулбарыг хэвлэх, эрхийн шилжүүлэг, баримтыг хүчингүй болгохыг хариуцдаг. ЕСХ Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн сангаас гаргасан цахим агуулахын баримт нь хадгалуулсан барааны хууль ёсны эрхийг илэрхийлдэг. Цахим агуулахын баримтыг ЕСХ төвлөрсөн хадгаламжийн функцээр дамжуулан ЕСХ дээр шилжүүлж, тохиролцож болно. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нь хадгаламж эзэмшигч бүрд тус тусад нь данс хөтөлдөг.

Логистикийн удирдлага: Логистик нь түүхий эдийн арилжаан дахь нийлүүлэлтийн гинжин хэлхээний чухал хэсэг нийлүүлэлтийн гинжин хэлхээ нь тээвэрлэлт, хүргэлт, хүлээн авах, хадгалалт, удирдлагыг багтаадаг. Нийлүүлэлтийн гинжин хэлхээний үүрэг нь яг цагт нь зөв газар, чанарын шаардлагын дагуу хүргэх.

Тээвэрлэлт: Түүхий эдийг төмөр замаар, усан онгоцоор, ачааны машинаар тээвэрлэдэг ба стандартад нийцсэн контейнерээр тээвэрлэх үүрэгтэй.

Мөрдөн байцаах үйл ажиллагаа (enforcement): АНУ-ын Бараа таваарын фьючерсийн хороо нь мөрдөн байцаах үйл ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага бөгөөд анх зөвхөн АНУ-д мөрдөн байцаах үйл ажиллагаа явуулдаг байсан бол түүхий эдийн бараа, бүтээгдэхүүний арилжаатай холбоотой MENA-ийн бус нутагт мөрдөн байцаах үйл ажиллагаа хийх болсон. Мөрдөн байцаах үйл ажиллагаа нь залилан, зах зээлийг урвуугаар ашиглах, хууль зөрчсөн үйлдэл, хэвийн бус арилжааг шалгадаг байна.

АНУ-ын Бараа таваарын фьючерсийн хороо нь мөрдөн байцаалт хийх мэдээлэл авах нээлттэй эх сурвалжтай ба АНУ-ын иргэншилгүй арилжаанд оролцогчдыг шалгах олон талуудтай (Dubai Financial Services Authority and the Financial Services Regulatory Authority of Abu Dhabi гэх мэт) харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан мэдээлэл авч ажилладаг.

САНАЛ, ДҮГНЭЛТ

Түүхий эдийн биржийн арилжааны зах зээл нь үүсмэл санхүүгийн хэрэгсэлд суурилж үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн системийн хувьд нөлөөлөхүйц эрсдэл үүсгэх магадлал өндөр байдаг тул дэд бүтцийн хувьд эрсдэлийг бодитоор удирдаж чадах тооцооны байгууллага чухал үүрэг гүйцэтгэдэг. Түүнчлэн үнэт цаасны биржтэй харьцуулахад түүхий эдийн бирж нь агуулах, тээвэрлэлт гэсэн нэмэлт функцийг шаардах, түүний удирдлагыг сайтар хэрэгжүүлэх механизм бий болгоход зөв тогтолцоог бүрдүүлдэг.

Түүхий эдийн биржид бүртгэлтэй бараа бүтээгдэхүүний санхүүгийн үүсмэл хэрэгслийг арилжихад нь холбогдох санхүүгийн зохицуулагч байгууллагаас зөвшөөрөл авдаг тул Санхүүгийн зохицуулах хороо үүсмэл санхүүгийн хэрэгслийг бүртгэх зохицуулалт бий болгодог.

Түүхий эдийн бирж түүхий эд тус бүрээр үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээ болон чанарын стандартыг боловсруулж, батлан зохицуулагч байгууллагаар батламжлуулах шаардлагатай.

АНУ-ын Түүхий эдийн фьючерсийн арилжааны хороо (CFTC)-нд мөрдөн байцаах үйл ажиллагааны чиг үүрэг хамаардаг ба олон улсын түвшинд холбогдох байгууллагуудтай хамтран мөрдөн байцаах ажиллагаа явуулдаг байна. Этиопын таваарын биржийн удирдлага (ECEA) нь хууль бус үйлдлүүдийг шалгаж, өөрийн харьяалалд хамаарах хэргийг шийдвэрлэх эсвэл эрүүгийн хэргийг зохих шүүхэд шилжүүлэх эрхтэй. Харин Санхүүгийн зохицуулах хороонд мөрдөн байцаах чиг үүрэг байдаггүй тул уг үйл ажиллагаа хязгаарлагддаг. Түүхий эдийн бирж дээрх үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаанд зөвхөн Монгол улсаас бус, хэд хэдэн улсаас оролцогч талууд оролцдог тул ижил төстэй байгууллагуудтайгаа хамтран мөрдөн байцаалт хийх шаардлагын улмаас Санхүүгийн зохицуулах хорооны эрхзүйн байдлын тухай хуулинд мөрдөн байцаах чиг үүргийг нэмж тусгах нь зүйтэй.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- ◆ Cunha, Rita. "The IOSCO Multilateral Memorandum of Understanding (MMoU): An International Benchmark for Securities Enforcement." Unif. L. Rev. 15 (2010): 677.
- ◆ Retrieved from: <https://www.iosco.org/library/pubdocs/pdf/IOSCOPD381.pdf>
- ◆ Financial Stability Board. The Financial Stability Aspects of Commodities Markets. 20 February 2023. Retrieved from: <https://www.fsb.org/wp-content/uploads/P200223-2.pdf>
- ◆ ICICI Securities Ltd. Legal and Regulatory Environment of Commodity Derivatives, Retrieved from: <https://www.icicidirect.com/ilearn/currency-commodity/courses/chapter-16-legal-and-regulatory-environment-of-commodity-derivatives>
- ◆ IOSCO. Principles for the Regulation and Supervision of Commodity Derivatives Markets. January, 2023. Retrieved from: <https://www.iosco.org/library/pubdocs/pdf/IOSCOPD726.pdf>
- ◆ ISDA Associate Membership Brochure 2018 Retrieved from: <https://www.isda.org/>
- ◆ БНХАУ–ын Далианы түүхий эдийн бирж Retrieved from: <https://www.dce.com.cn/>
- ◆ Этиопын таваарын бирж Retrieved from: <https://www.ecx.com.et/>





САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд

Цуврал №26



ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ, ТӨЛӨӨЛӨГЧ ГЭЖ ХЭН БЭ?

“Даатгалын зуучлагч” нь даатгагч болон даатгуулагчаас олгосон бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхлын төлөө, хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх, үүнийхээ төлөө хөлс, шагнал авах эрх бүхий этгээд юм.

Даатгалын зуучлагчийн давуу тал



Мэргэжлийн зөвлөгөө өгдөг



Эрсдэл үнэлдэг



Хамгийн тохиромжтой даатгалыг санал болгодог бөгөөд даатгалын компаниудын мэдээллийг 1 доороос аван харьцуулан сонгож өгдөг

Даатгалд яагаад зуучлагч хэрэгтэй вэ?

Даатгалын үйлчилгээг зуучлагчаар дамжуулан авснаар нэмэлт шимтгэл, хураамж төлдөггүйгээс гадна, даатгалын компанийн нийтэд санал болгосон нөхцөлөөс илүү хямд хураамжаар даатгуулах боломжтой болдог.

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд


Цуврал №26

“Даатгалын төлөөлөгч” гэж даатгагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүний нэрийн өмнөөс хэлцэл болон эрх зүйн бусад үйлдэл хийх үүрэг бүхий даатгагчийн томилсон буюу эрх олгосон этгээдийг хэлнэ.



Даатгалын зуучлагч, төлөөлөгчийн ялгаа

Зуучлагч



Даатгуулагчид үйлчилж, олон даатгалын байгууллагуудын тохиромжтой үйлчилгээг санал болгон түүнд зөвлөмж заавар өгдөг.

Төлөөлөгч



Нэг даатгалын компаниа төлөөлөн ажиллаж, тухайн компанийг өмнө үүрэг хүлээдэг.

1 хүн даатгалын төлөөлөгч, даатгалын зуучлагчийн үйл ажиллагааг давхар эрхлэх боломжгүй.




“ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН
ОРОЛЦОГЧИЙН ТУХАЙ” хуулийг дараах
QR кодыг уншуулан танилцана уу.

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ХОЛБООНЫ НӨӨЦИЙН САН БОДЛОГЫН ХҮҮГЭЭ 5–5.25 ХУВЬД ХЭВЭЭР ҮЛДЭЭЛЭЭ



2023 оны 6 дугаар сарын 14-ний өдөр АНУ-ын Холбооны нөөцийн сангаас бодлогын хүүг 5–5.25 хувьд хэвээр үлдээхээ зарлалаа. 2022 оны 03 дугаар сараас хойш нийтдээ 10 удаа дараалан Холбооны нөөцийн сан бодлогын хүүгээ өсгөөд байсан бол энэ удаа 5–5.25 хувьд хэвээр үлдээхээр шийдсэн нь мөнгөний хатуу бодлогын үзүүлэх үр нөлөөг мэдрэх, түүнд дүн шинжилгээ хийх боломжийг авчирна гэж үзсэнтэй холбоотой юм.

Энэхүү мэдэгдлийн дараа АНУ-ын засгийн газрын бондын болон ам.долларын ханш өссөн бол хөрөнгийн зах зээлийн голлох S&P 500 индекс 0.08 хувиар, Nasdaq Composite индекс 0.4 хувиар тус тус өсөж Dow Jones индекс 0.7 хувиар буурчээ.

Шинжээчдийн таамаглаж буйгаар Холбооны нөөцийн сан инфляцыг зорилтот 2 хувьд хүргэж бууруулахад бодлогын хүүг дахин өсгөх таамаглалтай бөгөөд АНУ-ын инфляц 9.1 хувиас 4 хувьд хүрч буурсан нь төдийлөн зорилтот түвшин очоогүй байгааг онцолж байна.

Эх сурвалж: Холбооны нөөцийн сан

КАНАДЫН ТӨВ БАНК БОДЛОГЫН ХҮҮГЭЭ СУУРЬ 25 НЭГЖЭЭР НЭМЭГДҮҮЛЖ СҮҮЛИЙН 22 ЖИЛИЙН ТҮҮХЭН ДЭЭД ТҮВШИН БОЛОХ 4.75 ХУВЬД ХҮРГЭЛЭЭ



Канадын Төв Банк 2022 онд 03 дугаар сараас хойш нийт найман удаа бодлогын хүүгээ өсгөж 4.50 хувьд хүргэсэн бөгөөд 2023 он гарснаас хойш түр зогсоосон. Харин энэ оны 6 дугаар сарын 7-ны өдөр бодлогын хүүгээ 25 суурь нэгжээр нэмэгдүүлж сүүлийн 22 жилийн хугацаанд түүхэн дээд хэмжээнд буюу 4.75 хувьд хүргэв.

Шинжээчдийн таамаглаж буйгаа Канадын Төв Банк зорилтот 2 хувиас давсан инфляцыг бууруулахын тулд 7 дугаар сард бодлогын хүүгээ дахин 25 суурь нэгжээр нэмэгдүүлэх төлөвтэй байна

Эх сурвалж: www.reuters.com

СОЛОНГОСЫН ТӨВ БАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ “ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЭРСДЭЛИЙГ НЭМЭГДҮҮЛЖ БАЙГААГ ОНЦЛОВ”



Солонгосын Төв Банкны ерөнхийлөгч Ри Чан Ён Төв Банкны 73 жилийн ойн баярт хэлсэн үгэндээ: “Орон сууцны зах зээл аажмаар сэргэж байгаа ч үл хөдлөх хөрөнгийн зээлийн үйлчилгээ нэмэгдэж байгаа нь инфляц тогтвортой болоогүй байгаа энэ үед санхүүгийн салбарын эрсдэлийг нэмэгдүүлж байгааг онцлов.”

Үл хөдлөх хөрөнгийн зээлийн үйлчилгээ нь Төв Банкнаас хяналт тавьдаггүй банк бус санхүүгийн фирмүүдэд шилжсэн тул Төв Банкнаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ илүү хязгаарлагдмал байгаа бөгөөд банк бус санхүүгийн фирмүүдийн хадгаламжийн эзлэх хувь банкнуудынхаас хэдийн давсан нь томоохон эрсдэлийг дагуулж байгаа юм.

Банкнаас бусад салбарын санхүүгийн зах зээлд эзлэх хувь нэмэгдэхийн хирээр Төв Банкнаас хэрэгжүүлж буй бодлого хангалтгүй байгааг дурдаж дунд болон урт хугацаанд санхүүгийн тогтворгүй байдал үүсгэхгүйн тулд холбогдох хяналтын байгууллагуудтай хамтран өрхийн өрийг буурах бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлнэ гэдгээ мэдэгдлээ.

Мөн эдийн засгийн ерөнхий төлөв байдлыг танилцуулж, суурь инфляц буурахад удаан хугацаа шаардагдах бөгөөд хэрэглээний үнэ буурсан ч суурь инфляц өндөр хэвээр байгаа тул инфляц буурч байна гэж итгэхэд эрт байгааг онцолсон юм.

Эх сурвалж: www.bloomberg.com

2023 ОНЫ 1-Р УЛИРАЛД ХЯТАДЫН ДНБ 4.5 ХУВИАР ӨССӨН НЬ ЗАХ ЗЭЭЛИЙН ХҮЛЭЭЛТИЙГ ДАВЛАА



Хятадын ДНБ 2022 оны 4 дүгээр улиралд 2.9 хувиар, 2023 оны 1 дүгээр улиралд 4.5 хувиар тус тус өссөн нь цар тахлын дараа Хятадын эдийн засаг эрчимтэй сэргэж буйг харуулж байна. Энэхүү өсөлтөд экспортын уян хатан бодлого, үл хөдлөх хөрөнгийн зах зээл эрчимтэй сэргэж байгаатай холбоотой бөгөөд шинжээчдийн зүгээс Хятадын эдийн засаг 2023 онд 5.7 хувиар өсөх таамгийг хэвээр үлдээж, 2024 онд Хятадын эдийн засаг 5.2 хувиар өснө гэж таамаглаж байна.

Эх сурвалж: www.kpmg.com




ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2023 оны 6 дугаар сарын 20-ны өдөр

S&P 500 /^GSPC/


4,409.59 -16.25 (-0.37%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /^N225/


33,607.08 -99.00 (-0.29%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /^FTSE/


7,742.72 +14.46 (+0.19%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite (^IXIC)

13,689.57 -93.23 (-0.68%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

© САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia